*Гүнзгий мэд*

# MONGOLIAN ECONOMY

2017. 04 САР (127)

www.mongolianeconomy.mn

**Зочин**

Жон Лангтри: Австралид боловсролын салбар нь уул уурхайгаасаа том

**Үзэл бодол**

Нийгмийн "дундчууд" гэж хэн бэ?




# ДУНДАЖ ДАВХАРГА

ҮНЭ 12,900₮

8 658000 679416

Зочин



# Жон Лангтри: Австралид боловсролын салбар нь уул уурхайгаасаа том

О.ТҮВШИН

*Манай сэтгүүл Австрали улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жон Лангтритай хэдэн хором ярилцлаа. Ноён Лангтри Австрали улсаас Монгол Улсад суугаа анхны Элчин сайд бөгөөд элчин сайдын яам нь саяхан Улаанбаатар хотноо үүдээ нээсэн билээ. Тэрбээр өмнө нь Берлин, Хонг Конг, Токио болон Бээжин зэрэг хотуудад дипломат алба хашиж явсан нэгэн. Бид Австрали-Монголын харилцаа, боловсрол, мал аж ахуйн сэдвээр яриа өрнүүллээ. Австралийн аж ахуйн нэгжүүд Монголын уул уурхайн салбарт томоохон арилжааны болон арилжааны бус үүрэг гүйцэтгэдэг юм. Тэдний тэргүүлэх хөтөлбөр болох Австрали-Монголын Олборлох Салбарын Хөтөлбөр нь олборлох салбарын сайжруулсан менежмент болон засаглалын замаар нийгэм, эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлэх зорилготой. Гэвч ноён Элчин сайд хэлэхдээ Австрали-Монголын харилцаа уул уурхайгаас ч өмнө гүнзгий байсан хэмээн ярьсан юм.*

**-2017 онд Австрали болон Монголын Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой тохиох гэж байна. Харин танай Элчин сайдын яам 2015 оны арванхоёрдугаар сард нээгдсэн нь Улаанбаатар хотод байгаа хамгийн залуу Элчин сайдын яам болсон. Тэгэхээр өнгөрсөн 2016 онд та бүхний ололт амжилт, мөн хамгийн хүндрэл, бэрхшээлтэй зүйлс юу байв?**

-Монгол Улсад ирж, улсынхаа анхны Элчин сайдын яамыг нээсэнд үнэхээр их баяртай байна. Австрали улс шинээр элчин сайдын яам тийм ч их нээгээд байдаг улс биш. Гадаад хэргийн сайд Жули Бишоп шинээр элчин сайдын яам нээхээр шийдсэн хоёр газрын нэг нь Монгол юм. Тэрбээр яагаад ийм шийдвэр гаргасан бэ гэхээр Австрали-Монголын харилцаа аль хэдийнээ бат бэх болсон байсныг олж харсан хэрэг. Тэрбээр Австрали болон Оюу толгой-Рио Тинтогийн харилцаа гэх мэт манай улсын компаниуд Монголын уул уурхайн салбарын хөгжилд хүчтэй байр суурь эзэлж байгааг мэдэж буй учраас эдийн засагтай холбоотойгоор энд элчин сайдын яам нээх болсон байх.





Хоёрдугаарт илүү өргөн хүрээтэй стратегийн утга санаа агуулж байсан. Бид Монгол Улсыг чөлөөт зах зээлийн эдийн засаг болон либерал ардчиллыг хөрш орнуудаасаа тийм ч их туслалцаа авалгүйгээр хөгжүүлж чадсаныг биширдэг. Үнэнийг хэлэхэд энэ бүс нутгийн ардчиллагчидтай хамтрахад таатай цаг ирсэн байна.

**-Манай хоёр орны хамтын ажиллагааны хамгийн том салбар бол мэдээж хэрэг уул уурхайн салбар. Энэ салбараас өөр өргөн хүрээнд хамтарч, хөрөнгө оруулах боломжтой салбар бий юу. Байгаа бол аль салбар вэ?**

-Мэдээж хэрэг Монголын уул уурхайн салбарт бидний арилжааны оролцоо хүчтэй байгаа боловч бидэнд Австрали-Монголын олборлох салбарын хөтөлбөр бий. Энэ нь Австралид алслагдсан шилдэг уул уурхайн хөтөлбөрүүдийг өндөр чанартай хөрөнгө оруулалтаар хөгжүүлсэн шилдэг туршлагыг Монголын уул уурхайн менежмент болон засаглалд нутагшуулах зорилготой юм.

Өөр нэгэн онцлох салбар нь боловсрол. Автралид боловсролын салбар нь уул уурхайн салбараас илүү том гэдгийг дэлхий даяар сайн ойлгодоггүй. Бид ялангуяа Монгол Улстай холбоотой нэг зүйлийг хэлмээр байна. Мэдээж та бүхний сайн мэдэх Australia Awards тэтгэлэгт хөтөлбөрийг манай улсаас олгодог. Энэ жил бид шинэ тэтгэлгүүд санал болгож байгаа бөгөөд одоогийн байдлаар 60 Монгол оюутан Австрали улсад тэтгэлэгтэй суралцаж байна.

Бас эдгээр тэтгэлгүүд магистрын оюутнуудад зориулсан тэтгэлэг гэдгийг онцлох хэрэгтэй. Харин бүхэлд нь авч үзвэл манай улсад ойролцоогоор 2000-2300 Монгол оюутан дээд боловсрол эзэмшиж байна. Энэ нь зөвхөн өмнөх жилийнхтэй харьцуулахад 40 хувиар өссөн. Бизнесийн хувьд ч тэр автраличууд болон монголчууд аль аль нь манай улсын өндөр чанартай боловсролыг үнэлж буйн хувьд ч тэр бидэнд маш таатай байна.

**Манай улсад ойролцоогоор 2000-2300 Монгол оюутан дээд боловсрол эзэмшиж байна. Энэ нь зөвхөн өмнөх жилийнхтэй харьцуулахад 40 хувиар өссөн.**

**-Ярианы сэдвээ жаахан өөрчилье. Дэлхийн хамгийн том 10 фермийн найм нь Австрали улсад байгаа. Танай улс фермийн бүтээгдэхүүнийхээ 60 хувийг экспортолдог. Монголын үе үеийн Засгийн газар мал аж ахуйн салбарыг илүү экспортын баримжаатай болгох талаар ярьдаг боловч гол төлөв эрүүл ахуй, ариун цэврийн асуудлын улмаас өнөөг хүртэл тийм ч их амжилтад хүрсэнгүй. Хөдөө аж ахуйн салбар өндөр хөгжсөн Австрали улсаас ямар сургамж авч болох вэ?**

-Эхний анхаарах зүйл бол мэдээж хэрэг тус салбараа дотооддоо өрсөлдөх чадвартай, тогтвортой болгох хэрэгтэй. Миний бодлоор бол хур тунадас багатай, эмзэг хөрстэй Монгол ба Австрали шиг орнуудад малын бэлчээр идшийг хэтрүүлэхгүй тохируулах нь Монгол Улсад тулгарч буй том сорилт болов уу. Та манай улсыг дэлхийд хамгийн том фермтэй гэж түрүүн дурьдсан. Үнэн хэрэгтээ эдгээр фермүүдийг цөөхөн хэдэн хүн авч явдаг бол Монгол Улс одоо хүртэл уламжлалт нүүдлийн мал аж ахуйгаас шилжиж шилжилтийн үедээ явж байна. Тохирсон идэш тэжээлийн хэмжээг олж малын чанарыг сайжруулж мөн бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх хэрэгтэй гэж бодож байна.

Хоёрдугаарт, хөдөө аж ахуйгаас ашиг хүртэж, олон улсад өрсөлдөхүйц байхыг хүсч байвал татаас дээр маш болгоомжтой хандах хэрэгтэй. Монгол Улс маш олон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд татаас олгодгыг би мэднэ. Австрали улс хэдэн жилийн өмнө татаасыг зогсоосон, яагаад гэвэл энэ нь үндсэндээ биднийг дампууруулж байсан. Дотооддоо экспортын салбарт татаас олгож байнаа гэдэг нь эдийн засгийн хувьд тийм ч ойлгомжтой бөгөөд тохиромжтой зүйл биш. Үүнээс гадна сонгогчид ч энэ талаар сайн бодоод үзвэл утгагүй зүйл гэдгийг нь ойлгоно. Тэдний төлдөг татварыг гадаадад хэн нэгний ширээн дээр хоол тавихад зарцуулж байна гэж юу гэсэн үг вэ? Тиймээс татаас болон татварыг сайн эргэцүүлэн бодож, салбараа өрсөлдөөнт хэлбэрээр

хөгжиж буй эсэхийг нь тунгаах хэрэгтэй болов уу.

Мэдээж дараачаар нь эрүүл ахуй болон ургамлын хорио цээр нь маш том асуудал. Үүнд ариун цэврийн хувьд хорио цээр болон малын эрүүл мэнд гэсэн хоёр асуудал байгаа. Үхрийн махан дээр өрсөлдөх давуу талыг бий болгое гэвэл тусгай бүтээгдэхүүн авч хэлэлцэж үзэхээс гадна маркетингаа органик бүтээгдэхүүн гэдэгт үндэслэж хийх хэрэгтэй. Зөв арга барилаа оллоо гэж батлахын тулд Монгол Улсад дотооддоо төсөөлж буйгаас хавьгүй их ажил хийх шаардлагатай. Надтай уулзсан олон монгол хүн манай улс гайхалтай органик махтай гэж хэлж байсан болович БНХАУ-аас хилээр маш их антибиотик орж ирж байгааг ч би мэдэж байна. Мал амьтдад эдгээр антибиотикыг хяналтгүй шахам өгч байгаа нь малын эрүүл мэндэд олон асуудал үүсгэж байна. Мөн энэ нь антибиотикийн эсрэг дархлааг ч үүсгэж болно. Мэдээж хэрэг экспортлох гэж байгаа бол эрүүл ахуй, ариун цэврийн дүрэм журамд захирагдхаас өөр аргагүй.

Нөгөө нь мэдээж олон улсын асуудал. Хэрэв та хаа нэгтээ хэн нэгэн хүнд юмаа зарахыг хүсч байгаа бол зөв хорио цээрийн протоколтой байх ёстой. Жишээ нь Австрали улс БНХАУ-д маш их хэмжээний үхрийн мах зардаг. Бид БНХАУ-тай чөлөөт худалдааны гэрээнийхээ хүрээнд илүү ихийг ч зарах учиртай болович Австралийн боловсруулах үйлдвэр гэх мэт газруудад маш чанга хяналт тавьдаг. Хятад улс худалдааг илүү хурдан явуулахын тулд эдгээр зүйлсийг шалгахгүй байна. БНХАУ болон бусад улс руу экспорт хийхийг хүсч байгаа бол тэдэнтэй Засгийн газар хоорондын эрүүл ахуй, ариун цэврийн зохицуулалт дээр тохиролцоонд хүрэх хэрэгтэй.

Манай улс Монгол улс руу экспортлох сонирхолтой байгаа зарим бараа бүтээгдэхүүн байгаа болович одоогийн байдлаар Монгол хонины махны импортыг хориглосон байгаа гэж ойлгож байна. Бид энд хурга, хурганы мах худалдах сонирхолтой байна. Манай бүтээгдэхүүн танай улсынхаас тэс өөр. Манай мах нэг настай хурганы мах бол танайх гол төлөв хоёр настай байдаг. Тэгэхээр бидний бүтээгдэхүүн илүү залуу бөгөөд та бүхний бүтээгдэхүүнтэй өрсөлдөхгүй гэсэн үг. Миний ойлгож буйгаар хориг тавих болсон гол шалтгаан нь хэдэн жилийн өмнө зуд болж малын тоо толгойг бууруулсан учир Засгийн газар дотоодын малчдыг хамгаалахын тулд махны импортыг зогсоосон. Үүнийг би хувьдаа ойлгож байна. Гэхдээ бидэнд энэ тал дээр боломж байгаа гэж харж байгаа учир Монгол Улсын Засгийн газартай эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн стандартын тухай ярилцах хэрэгтэй гэж бодож байна. Бид үүнийг судалж байгаа.

Сайн тал нь бид махны экспортлогчдын чадавхыг дээшлүүлэхэд туршлага хуваалцаж болно. Хэрэв Монгол Улс сонирхож байвал ямар нэгэн аргаар үүнийг хийж болох байх. Би ХАА-н эдийн засгийг удаан хугацааны турш сонирхож байгаа, 1980 оны үеэс л БНХАУ дахь Австралийн Элчид сайдын яаманд ажиллаж байх үеэс сонирхсон. Тиймээ танай улс ашигтай ХАА экспортын салбартай болох мөрөөдөлдөө хүрье гэж бодож байгаа бол маш их зүйл хийх хэрэгтэй байна. Та бүхэнд туслахад бэлэн олон хүмүүс байгаа.

**-Ойрын хугацаанд манай хоёр орны хооронд ямар нэгэн албан ёсны айлчлал болох уу? Ноён Турнбулл манайд айлчлах болов уу?**

-Би ноён Турнбуллыг айлчлал хийнэ гэж бодохгүй байна. Гадаад хэргийн сайд Бишоп энэ жил Монголд айлчлал хийх өндөр магадлалтай. Хатагтай Бишоп өмнө жил Монголд болсон АСЕМ-д ирэхийг хүсч байсан болович сонгууль таарч Австрали улс тодорхой Засгийн газаргүй байж таарсан. АСЕМ болж байх үеэр бид санал хураалтын үр дүнг тоолж дуусагүй байсан учир тэрбээр ирж чадаагүй. Хатагтай Бишоп энэ жил Монголд ирэхгүй бол харин би их гайхах болно. Би түүнийг энд айлчлал хийхийг хүсч байгааг мэдэж байна, тэр ямар нэгэн арга заавал олох болно. Энэ нь хоёр орны хувьд маш ашигтай айлчлал байх болно.

Энэ оны есдүгээр сарын 15-нд манай хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой тохиох учир тэр цаг үе ч түүний айлчлалд тохиромжтой байж болох юм.

**-Ярилцлагаа өндөрлөхийн өмнө таны талаар хувийн асуулт асууя. Таны мэргэжил инженер гэж дуулсан?**

-Яг ч мэргэжил биш л дээ. Би өөрийгөө ихэвчлэн бүтэлгүйтсэн инженер гэж танилцуулдаг юм. Би Шинэ Өмнөд Уэльсийн Их Сургуульд сурч байсан болович инженерээр хэзээ ч ажиллаж байгаагүй. Би Токиогийн Гадаад судлалын их сургуулийг хэл шинжлэлээр төгссөн. Түүнээс хойш гадаад харилцаатай ямар нэгэн байдлаар холбогдож ирсэн.

**-Таныг япон хэлээр ярьж байхыг харлаа. Монгол хэлдээ хэр вэ?**

-Сайжирч байна (Монголоор хэлэв) гэж хэлэх л зүйтэй болов уу. ■